

ОЛГОЙ БУЛАГ ХХК

Геологи, уул уурхай, үйлчилгээ

Хаяг: Улаанбаатар хот, Чингэлтэй

дүүрэг, 4-р хороо, 51-р байр, 4 давхар

Утас: 80884044, 80051126

Э-шуудан: olgoi_bulag@yahoo.com

2025.09.24 № 25/31

танай _____-ны № _____-т

БАЙГАЛЬ ОРЧИН, УУР АМЬСГАЛЫН
ӨӨРЧЛӨЛТИЙН ЯАМНЫ БАЙГАЛЬ
ОРЧНЫ ҮНЭЛГЭЭ, АУДИТЫН ХЭЛТЭСТ

Хүсэлт гаргах тухай

Манай компани нь Сүхбаатар аймгийн Сүхбаатар сумын нутагт MV-017611 ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий 470.82 га талбайд "Төхөм" нүүрсний ордын төсөл хэрэгжүүлж байна.

Тус төслийн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлан 2022 онд батлагдаж, 2024 онд үйл ажиллагаа явуулаагүй болно. Ингээд 2025 онд үйл ажиллагаа явуулахаар төлөвлөн 2025 оны 05 дугаар сард нийгмийн хариуцлагын хүрээнд 5.0 сая төгрөгөөр 400 ширхэг мод тарьж Сүхбаатар сумын 2-р багт хүлээлгэн өгсөн.

Уулын ажлын төлөвлөгөө 9-р сард батлагдсанаас шалтгаалан бидний ажиллах хугацаа багассан буюу зөвхөн 10 дугаар сард үйл ажиллагаа явуулах нөхцөл үүсээд байна. Иймд манай компанийн дээрх шалтгааныг харгалзан үзэж байгаль орчны менежментийн төлөвлөгөөг батлан өгч гүн туслалцаа үзүүлнэ үү.

Хүндэтгэсэн,

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

О.БАТБОЛД





СҮХБААТАР АЙМГИЙН
СҮХБААТАР СУМЫН ХОЁРДУГААР
БАГИЙН ЗАСАГ ДАРГА

Жанжин гудамж, 2-р баг, Хайлаастай,
Сүхбаатар сум, 22035

Цахим шуудан: sukhbaatarsum@gov.mn

2025. 08.20 № 186
танай _____-ны № _____-т

АМГТГ-ИЙН УУЛ УУРХАЙН ХЭЛТЭСТ

Сүхбаатар аймгийн Сүхбаатар суманд үйл ажиллагаа явуулдаг "Олгой булаг" ХХК ны 2023 онд Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан "Тэрбум мод" үндэсний хөтөлбөр, дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний хүрээнд сумын төвийн баруун хойд талд Бурханы хөшөөний хажууд 1100 ширхэг мод тарьсан болно.

Мөн талбайд 2025 онд Сүхбаатар сумын "Алтан талын агь идээ" хоршоо нь арчилгаа усалгаа хийж 400 мод нэмж тарьсан нь үнэн болно.



ДАРГА

Ц.СҮХБОЛД

ГАРЧИГ

НЭГ. ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА.....	2
Төслийн зорилго:	2
Төслийн талбайн байршил, хэрэгжих орчны тойм.....	3
ХОЁР. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА.....	4
Төслийн ерөнхий мэдээлэл.....	4
Нийгэм эдийн засгийн товч танилцуулга.....	5
ГУРАВ: ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГНӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ	6
Төслийн гол болон сөрөг нөлөөлөл.....	6
ДӨРӨВ: ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ.....	8
ТАВ. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	9
ЗУРГАА. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	9
ДОЛОО. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭХ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	10
НАЙМ. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	10
ЕС. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ.....	10
АРАВ. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ.....	10
АРВАН НЭГ. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	11
АРВАН ХОЁР. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР.....	11
АРВАНГУРАВ. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ	12
АРВАНДӨРӨВ. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ.....	13

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт №1. Төслийн ерөнхий мэдээлэл	2
Хүснэгт №2. Төслийн талбайн солбилцол	3

ЗУРГИЙН ЖАГСААЛТ


Зураг №1. Талбайн байрзүйн зураг.....	2
---------------------------------------	---

НЭГ. ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

“Олгойбулаг” ХХК-ийн эзэмшиж буй MV-017611 ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий 470.82 га талбай “Төхөм” нүүрсний орд нь Сүхбаатар аймгийн Сүхбаатар сумын нутаг дэвсгэрт байрладаг.

Тус “Төхөмийн” хүрэн нүүрсний орд газар нь засаг захиргааны нэгжийн хувьд Сүхбаатар аймгийн Сүхбаатар сумын нутагт харъяалагддаг ба Улаанбаатар хотоос зүүн тийш 650 км, Сүхбаатар сумын төвөөс зүүн урагш 36 км-т оршино.

Зураг №1. Талбайн байрзүйн зураг



Хүснэгт №1. Төслийн ерөнхий мэдээлэл

Төслийн нэр:	“Төхөм” хүрэн нүүрсний ордыг ил уурхайн аргаар ашиглах төсөл
Төсөл хэрэгжүүлэгч:	“Олгойбулаг” ХХК
Улсын бүртгэлийн дугаар:	9011122066
Тусгай зөвшөөрлийн дугаар:	MV-017611
Хаяг:	Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг, 4-р хороо, Баруун Сэлбийн гудам, 51-р байр 401 тоот

Төслийн зорилго:

“Төхөм” хүрэн нүүрсний ордыг ил уурхайн аргаар ашиглах төслийн үндсэн зорилго нь Монгол Улсын нүүрсний салбарын дунд болон урт хугацааны тогтвортой хөгжлийг хангах, хууль

эрх зүй, татварын орчинг тогтвортой байлгах, эрэл хайгуулын ажлыг эрчимжүүлэх, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй, байгаль орчинд ээлтэй бөгөөд нүүрс олборлох, боловсруулах техник технологийг сайжруулж нүүрс авалтыг өсгөх, нүүрсний нэмүү өртөг шингэсэн эцсийн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх, уул уурхайн салбараас эдийн засагт оруулах өгөөжийг дээшлүүлэх, олон улсын хэмжээнд өрсөлдөх чадварыг өсгөхөөр төрөөс авч хэрэгжүүлж байгаа бодлогын хүрээнд ордын талбайд олборлох, үйл ажиллагааг явуулж, ордын нөөцийг ашиглалтын үе шатанд нэмэгдүүлэх, тогтвортой үйл ажиллагаа явуулахад чиглэнэ.

Төслийн талбайн байршил, хэрэгжих орчны тойм

“Төхөм” нүүрсний орд нь нь засаг захиргааны нэгжийн хувьд Сүхбаатар аймгийн Сүхбаатар сумын нутагт харьяалагддаг ба Улаанбаатар хотоос зүүн урагш 650 км, Сүхбаатар сумын төвөөс зүүн урагш 36 км зайд MV-017611 тоот ашиглалтын тусгай зөвшөөрлийн 470.82 га талбай оршино. Төслийн талбайн солбицлын цэгүүдийг доорх хүснэгтэд байршлыг доорх зурагт тусус үзүүлэв.

Хүснэгт №2. Төслийн талбайн солбилцол

Цэгийн дугаар	Уртраг			Өргөрөг		
	градус	минут	секунд	градус	минут	секунд
1	114	15	5.0	46	33	51.76
2	114	15	5.0	46	33	39.22
3	114	15	32.39	46	33	39.22
4	114	15	32.39	46	33	01.76
5	114	13	2.4	46	33	01.76
6	114	13	2.4	46	33	51.75

ХОЁР. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

“Олгойбулаг” ХХК нь Сүхбаатар аймгийн Сүхбаатар сумын нутагт байрлах MV-017611 тоот тусгай зөвшөөрөлтэй “Төхөм” хүрэн нүүрсний ордод 2013-2014 онд нарийвчилсан хайгуулын ажлын үр дүнд бодитой болон боломжтой (В+С) зэрэглэлээр 37.6 сая.тн хүрэн нүүрсний нөөцийг батлуулсан ба уг нөөцийн хэмжээнд олборлолт явуулж, баяжуулах, борлуулах үйл ажиллагааг явуулна. “Төхөм” хүрэн нүүрсний ордод бодогдсон бодитой болон боломжтой нөөцийг үндэслэн ордыг ил уурхайн аргаар ашиглах ТЭЗҮ-ийг 2019 онд боловсруулж ЭБМЗ-ийн хурлаар хэлэлцүүлсэн байна. Төслийн эхний үе шатны 10 жилийн хугацаанд явуулах ба жилд 1000 мян.тн хүчин чадлаар ажиллахаар тооцоолсон байна.

Төслийн ерөнхий мэдээлэл

Газар зүйн мужлал. Зүүн бүсийн тал хээрийн бүсэд хамаарагдах ба газар зүйн ангиллаар тус талбай нь дов толгод зонхилсон томоохон хөндий, жижиг хоолой, жалга элбэгтэй намхан бэсрэг уулын бүсэд багтдаг.

Уур амьсгал. Эх газрын эрс тэс уур амьсгалтай, жилд дундажаар 50-100 мм тунадасунаж нийт хур тунадасны 50% нь зуны улиралд ордог.

Өвлийн 1-р сард дундажаар хасах 15-27 орчим хэм хүйтэн байдаг. Салхины чиглэл голдуу баруун, баруун хойноосоо салхилдаг. Өвөл цас багахан хэмжээгээр унадаг, агаарын даралт дундажаар 848-880 атм, чийглэг нь 50-60 хувь байдаг. Хур тундас ерөнхийдөө ховор ба 12-р сарын дунд үеэс цас унаж цасан бүрхүүлтэй болдог.

Ургамал, ус, ан амьтан. Тал хээрийн бүсэд ургадаг бутлаг болон өвслөг ургамлууд бүгд ургадаг уурхайн талбай орчимд ямар нэгэн гол горхи, булаг шанд байхгүй. Хаяа нэг эвдэрч ажилгаагүй болсон худаг тааралдана. Борооны хэмжээнээс хамааран зарим нэг хотгор газруудаар тогтоол ус үүсдэг. Цагаан зээрийн сүрэг тааралдахаас гадна тарвага зурам, үнэгчоно, туулай зэрэг ан амьтан элбэгтэй. Гэвч сүүлийн жилүүдэд тарваганы тоо эрс цөөрсөн байна.

Бүс нутгийн дэд бүтэц. Халх Монголчууд нутагшин амьдрах ба үндсэн эрхлэх аж ахуй нь мал аж ахуй. Сүхбаатар сумын төвд, сумын захиргаа, хүн эмнэлэг, холбоо, дунд сургууль, шатахуун түгээх станц, дэлгүүр, үүрэн холбооны станц, соёлийн төв зэрэг соёл үйлчилгээний байгууллагууд ажилладаг. Баруун-Урт хотоос Төхөмийн хүрэн нүүрсний орд хүртэл шороон замаар холбогдоно.

2018 оны сүүлчээс эхлэн “Олгой булаг” ХХК нь Төхөм уурхайгаас Бичигт боомт хүртлэх нүүрс тээвэрлэх замын зөвшөөрлийг холбогдох байгууллагуудаас хуулийн дагуу авч, өөрийнхөрөнгөөр зам засварын ажлыг эхлүүлээд байна.

Нийгэм эдийн засгийн товч танилцуулга

Төсөл хэрэгжих суманд ажлын байр нэмэгдэх, орон нутгийн худалдан авалт сайжрах, төсөл хэрэгжих хугацаанд аж ахуйн нэгжийн орлогын албан татвар, нийгмийн даатгал болон эрүүл мэндийн даатгалын шимтгэл, авто машин болон өөрөө явагч механизмийн албан татвар, эдэлбэр газар ашигласны төлбөр болон бусад татвар төлбөрийг Монгол улсад мөрдөгдөж буй хууль тогтоомжийн дагуу тооцоолон татвар хэлбэрээр улс болон орон нутгийн төсвийн санд оруулах, зэрэг ихэвчлэн эерэг нөлөөлөл үзүүлэх боломжтой байна. Гэхдээ төслийг хэрэгжүүлэх явцад байгаль хамгаалах үйл ажиллагааг хэрэгжүүлэхгүй байх зэргээр орон нутгийн иргэдтэй үл ойлголцол бий болж болзошгүй тул төслийн явцад орон нутгийн иргэдтэй хамтран ажиллах болно.

ГУРАВ: ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГНӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

Төслийн гол болон сөрөг нөлөөлөл

“Төхөм” хүрэн нүүрсний ордыг ил уурхайн аргаар ашиглах төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд учруулж болзошгүй дээр дурьдсан сөрөг нөлөөллөөс цаашид төсөл хэрэгжих явцад ордыг ухаж, ачиж зөөх, овоолго үүсгэх, алт ялгасан хоосон чулуулгын овоолгоноос тоос үүсэж салхины нөлөөгөөр орон зайд тархах нөлөөллийг хамгийн бага байлгахын тулд тоног төхөөрөмж ажиллаж буй талбай, мөрөгцгийг тогтмол хэвийн хэмжээнд байлгах.

Байгаль орчинд: Төслийн үйл ажиллагаанаас 42 сөрөг нөлөөллийг байгаль орчны бүрэлдэхүүн хэсэг тус бүрд үзүүлэхээр байна. Үүний 3 буюу 7.1% нь “бага”, 19 буюу 45.2% нь “дунд”, 18 буюу 42.8% нь “их”, 2 буюу 4.8% нь “маш их” гэсэн нөлөөллийн үнэлгээний зэрэгт хамаарагдаж байна. Эндээс үзэхэд төслийн зүгээс байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийн хэмжээ дундаас их хэмжээнд байхаар байна. Төслийн үйл ажиллагаанаас үзүүлэх сөрөг нөлөөллийн хэмжээ агаарын чанарт 16%, газрын гадарга, хэвлийд 19%, хөрсөн бүрхэвчид 17%, газрын доорх усанд 14%, ургамлан нөмрөгт 17%, амьтны аймагт 17% гэсэн үзүүлэлт гарч байгаа ба газрын гадарга, хэвлийд үзүүлэх нөлөөлөл илүү байна.

Сөрөг нөлөөллийг бууруулах арга:

- ✚ Тоосжилт үүсгэх гол эх үүсвэрүүдээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг төслийн эхний үе шатанд төлөвлөн, цаашид энэхүү сөрөг нөлөөллийг бууруулсан арга, туршлага, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн, дэвшилтэт техник, технологийг нэвтрүүлж ашиглах
- ✚ Хөрс хуулсан талбай болон эвдрэлд орсон газрын боломжтой хэсгийг нь тухай бүрт нь үржил шимт хөрсөөр бүрхэж ургамалжуулах
- ✚ Газар шорооны ажлын үед үржил шимт хөрсний хуулалт, хадгалалт, овоолгыг стандартын дагуу хийх
- ✚ Хөрсний овоолгыг салхинд хийсч, тоос шороо дэгдэхээс урьдчилан сэргийлж, овоолго түүний ойр орчимд салхины хурд бууруулах хаалт хийх
- ✚ Овоолгыг цаг тухайд нь тэгшилж, нягтруулах, хэлбэржүүлэх, чийглэж гадаргууг дагтаршуулах зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай
- ✚ Төслийн талбайн дотоод тээвэрлэлтийг аль болох олонсалаа замгаргахгүйгээр тээвэрлэх
- ✚ Орчны агаарт ялгаруулах хорт утаа хийг багасгахын тулд техникийн тогтмолзасвар, үйлчилгээг хийж байх
- ✚ Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө боловсруулах, хэрэгжүүлэх,
- ✚ Тээвэрлэлтийг явуулахдаа замын тогтсон маршрут гаргах, мөрдүүлэх, мөн хүнд даацын тээврийн хэрэгсэлийн зөөвөрт явах үеийн хурдыг тогтоох (хурдтай явах тусам тоосжилт нэмэгдэн техникт эвдрэл гарна) хяналт тавих,

- ✚ Хатуу хаягдлыг ахуйн гарал үүслээр нь ялган ангилж хадгалах, төвлөрсөн цэгүүдэд зайлуулах хэрэгтэй
- ✚ Түр амьдрах байр болон засварын хэсэгт бий болох ахуйн болон шатахуун, тослох материалын хаягдал үерийн усаар зөөгдөж хөрс бохирдохоос сэргийлж, зориулалтын саванд цуглуулах, төв суурин газарт зөөвөрлөж зайлуулах шаардлагатай
- ✚ Усны чанарт тогтмол хяналт шинжилгээ хийж байх

Хүний эрүүл мэндэд:

Төслийн үйл ажиллагааны явцад үүсэх тоосжилт, дуу чимээ, техник, тоног төхөөрөмжийн хөдөлгөөний аюулгүй байдал зэрэг уурхайн ажилчид, орон нутгийн иргэдийн эрүүл мэнд, аюулгүй байдалд үзүүлэх нийт 30 нөлөөллийг тооцов.Тэдгээр нөлөөллүүдийн 14 буюу 45% нь бага, 16 буюу 55% нь дунд зэргийн нөлөөллийн үнэлгээнийзэрэгт хамрагдаж байна.

Хөдөлмөрийн тухай хууль, ХАБЭА тухай хууль, бусад холбогдолтой дүрэм журам, стандартын шаардлагуудыг мөрдөх, дотоодын хяналтын журам аюулгүй ажиллагааны заавар, зааварчилгааг нийт ажилтнуудад мөрдүүлэх, хяналт тавих шаардлагатай.

ДӨРӨВ: ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ

“Олгойбулаг” ХХК-ийн Сүхбаатар аймгийн Сүхбаатар сумын нутагт хэрэгжүүлж буй “Төхөм” нүүрсний ордын төслийн хүрээнд төсөл хэрэгжүүлэгчийн мөрдөн ажиллах байгаль орчны менежментийн төлөвлөгөөг “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай” Монгол Улсын хууль, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10-р сарын 29-ны өдрийн А/618 тушаалаар батлагдсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”, Байгаль орчин аялал жуулчлалын яамнаас гаргасан ерөнхий үнэлгээний дүгнэлтэд заасан шаардлагын дагуу боловсруулав.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зорилго, зорилт, хамрах хүрээ

Тухайн төслийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө (БОМТ)-ний зорилго нь төслийн бүхий л үе шатанд байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээг төслийн хэрэгжилтийн хүрээнд авч үзэн, холбогдох зардлыг бодитоор төлөвлөх, улмаар төсөл хэрэгжүүлэгч энэхүү төлөвлөгөөг дагаж мөрдсөнөөр байгаль орчин, нийгмийн хамгааллын үүргээ хангах нөхцөлийг бүрдүүлэхэд оршино.

БОМТ-ний үндсэн зорилгыг хангахын тулд төсөл хэрэгжүүлэгчийн санхүүгийн чадавхийн хүрээнд нийгмийн хариуцлагыг өндөржүүлэхэд чиглэсэн дараах зорилтыг хангана. Үүнд:

- ✚ БОМТ-нд тусгасан ажлын дараалал, түүнийг хийж гүйцэтгэснээр хүрэх үр дүнг нөхөн сэргээлтэд тавих шаардлагын хэмжээнд хүргэх;
- ✚ БОМТ-ний хэрэгжилтийг төсөл хэрэгжүүлэгч өөрөө болон орон нутгийн оршин суугчдын зүгээс хэрхэн хянаж, харилцан хамаарал бүхий бодит үр дүнд хүрэх;
- ✚ БОМТ-г зохих ёсоор хэрэгжүүлснээр төсөл хэрэгжүүлэгчийг хөндлөнгийн хяналт, шалгалтад бэлэн байлгах нөхцөлийг бүрдүүлнэ.

БОМТ нь төслийн үйл ажиллагааны цар хүрээнд байгаль орчин, нийгмийн хамгааллын дараах асуудлыг хамарч, хэрэгжүүлэх арга хэмжээг төлөвлөнө. Үүнд:

- ✚ Төслийн хүрээнд бий болох сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээг төлөвлөж, холбогдох зардлыг тооцох;
- ✚ Нөхөн сэргээх, нөхөн хамгаалах ажлыг төлөвлөж, зардлыг тооцох;
- ✚ Түр нүүлгэн шилжүүлэлт хийх ажлын дэс дараалал, зохион байгуулалт, холбогдох зардлыг тооцох;
- ✚ Осол, эрсдэл, аюултай нөхцөл байдлын үед хүний эрүүл мэнд болон хүрээлэн буй орчныг хамгаалах бодлогыг тодорхойлох;
- ✚ Орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх арга замыг зааж, холбогдох зардлыг тооцох;
- ✚ Нөхөн сэргээлтийн талаарх мэдээллийг олон нийтэд таниулах зэрэг асуудлыг тусгана.

2025 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд нийт **7,585,000.0₮** төсөвлөхөөр тооцов.

ТАВ. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, төг	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8	9
1	Агаарын чанар	Уурхайн олборлолтын үе шатанд тоосжилт ихээр үүсэх үед усалгаа хийх	Уурхайн талбай	м³	1,500,000.0₮			Ажиллах хугацаанд	Агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэмжээ MNS 5885:2008
2		Уурхайд ашиглагдаж байгаа авто машин техникүүдийн янданд шүүлтүүр тавих		ш	-			Х сард	
3									
4	Хөрсөн бүрхэвч	Олон салаа зам гаргахгүйн тулд тэмдэг замын тэмдэг тэмдэглэгээ байрлуулах	Уурхайн талбай	ш	185,000.0₮	3	555,000.0₮	2025 онд	-
5	Нийт зардал		2,055,000.0₮						

ЗУРГАА. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

2025 оны үйл ажиллагаа тогтворжоогүй байгаа тул нөхөн сэргээлтийн үйл ажиллагаа явуулахгүй болно. Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд сумын төвд хайлаас, улиас зэрэг 400 ширхэг модыг 5,000,000.0 төгрөгөөр тарихаар төлөвлөөд байна.

ДОЛОО. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭХ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Уурхайн үйл ажиллагаа тогтворжоогүй тул дүйцүүлэн хамгааллын төлөвлөгөө хэрэгжих боломжгүй байна.

НАЙМ. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Төсөл хэрэгжиж буй талбайн эргэн тойронд айл өрхүүд байхгүй тул нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө хэрэгжихгүй.

ЕС. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Төсөл хэрэгжиж буй талбайд археологи, палеонтологийн дурсгал байхгүй тул түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө хэрэгжихгүй.

АРАВ. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8
1	Гал түймэр гарах	Галын хор, галын булан байгуулах, Галын дүгнэлтийн хугацааг сунгуулах	Уурхайн кэмп	1	1,500,000.0₮		2025 онд	-
2	Нийт зардал		1,500,000.0₮					

АРВАН НЭГ. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, төг	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8	9
1	Ахуйн	Үүссэн хог хаягдлыг Сүхбаатар аймгийн ТҮК-тэй хийсэн гэрээний дагуу зайлуулах	Төслийн талбай	Сард 1 удаа	240,000.0₮	8	1,920,000.0₮	2025 онд	Хог хаягдлын тухай хууль /2017 он/
Нийт зардал					1,920,000.0₮				

АРВАН ХОЁР. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд		Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Давтамжийн тоо	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Тайлбар	Баримтлах стандарт, арга, аргачлал
Агаар	-Тоосжилт (PM10, PSM, PM2.5) -Ажлын байрны эрүүл ахуйн үзүүлэлтүүд (тоос, дуу чимээ, гэрэлтүүлэг, чийгшил болон физик бохирдлын түвшин) -Бохирдлын цэгэн эх үүсвэр (CO ₂ , SO ₂ , NO ₂ , CO)	Ажлын байрны дотоод орчин Уурхайн карьер Технологийн зам	Жилд 1 удаа	1 удаа	75,000.0₮	75,000.0₮	-	“Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага” MNS 4585:2016
	-Хөрсний ерөнхий хими -Хүнд металл	Уурхайн карьер Хогийн цэг	Жилд 1 удаа	1 удаа	25.000₮*6 цэг (Хөрсний ерөнхий хими) 25.000₮*4 цэг (Хүнд металл) * “Ланд овнер” ХХК-ийн тариф”	250,000.0₮	-	Хөрсний чанар. Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ MNS 5850:2019

“Төхөм” нүүрсний ордын 2025 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд		Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Давтамжийн тоо	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Тайлбар	Баримтлах стандарт, арга, аргачлал
Ус	Ерөнхий ерөнхий химийн үзүүлэлт	Гүний худаг	Жилд 1 удаа	1 удаа	45,000₮ **"Монгол-Ус" ТӨҮГ-ын Усны лабораторийн тариф	45,000.0₮	-	MNS 0900:2005 Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ
	Түлш шатахуун, томилолтын зардал	Дээж авалтад шаардлагатай зардлыг нэгдсэн дүнгээр оруулахад (шатахуун, байр, хоол) 692,500.0₮ зарцуулна.						
НИЙТ		-	-	-		1,062,500.0₮	-	-

АРВАНГУРАВ. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Урьдчилан тооцсон төсөв	Хэрэгжүүлэх хуваарь			Хариуцсан албан тушаалтан	Тайлбар
			2025 он				
			Сар	Сар	Сар		
	1	2	3	4	5	6	7
1	Тухайн жилийн менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах	Дотоод төлөвлөлтөөр	2025 онд			“Олгойбулаг” ХХК	-
2	Орон нутгийн тавьсан шаардлагыг хэрэгжүүлэх, хамтарч ажиллах	-	-				-
	Нийт	-					

**АРВАНДӨРӨВ. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙГ
НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ**

№	БОМТ, БОМТ-ний хэрэгжилтийг тайлагнах оролцогч талууд	Тайлагнах хэлбэр	Мэдээллийн агуулга	Зохион байгуулах хугацааны тов	Тайлагнах зардал, төг	Хариуцан зохион байгуулах албан тушаалтан/ажилтан	Зохион байгуулах газар
	1	2	3	4	5	6	7
1	БОУАӨЯ, “Олгойбулаг” ХХК	Тайлан	Тухайн жилийн менежментийн төлөвлөгөөний биелэлт тайлан	11-р сарын 01-ний дотор	-	Компаний удирдлага, мэргэжилтэнүүд	
2	Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Хүрээлэн буй орчны бодлогын хэрэгжилтийн газар	Тайлан	Тухайн жилийн БОМТ	12-р сарын 1-ний дотор	-	“Олгойбулаг” ХХК-ийн мэргэжилтэнүүд БОМТ-ыг боловсруулах	

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардал

№	Хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө	Мөнгөн дүн, төг
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	2,055,000.0₮
2	Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	5,000,000.0₮
3	Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	-
4	Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө	-
5	Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	-
6	Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	1,500,000.0₮
7	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	1,920,000.0₮
8	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	1,062,500.0₮
9	Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	-
10	Тухайн жилийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний биелэлтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө	-
11	Нийт зардал	11,537,500.0₮